




ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА -2019



2020 он

Гарчиг

ОРШИЛ

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

I.1 Мал аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

I.2 Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт

I.3 Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт

ХОЁР. 2019 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ҮР ДҮН

II.1. Малтай өрх болон малчин өрх, малчдын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт

II.1.1 Малтай өрх, малчин өрхийн тоо

II.1.2 Малчдын мэдээлэл

II.1.3 Малчдын ахуйн зарим үзүүлэлт

II.2. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

II.2.1 Малын тоо

II.2.2 Сүргийн бүтэц

II.2.3 Иргэдийн хувийн малын тоо

II.2.4 Хээлтэгч мал

II.2.5 Төл бойжилт

II.2.6 Том малын зүй бусын хорогдол

II.2.7 Малын хээл хаялт, сувайралт

II.2.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

II.2.9 Малын хэрэглээний зарлага

II.3. Тэжээвэр амьтад

II.4. Малжуулалтын талаарх мэдээлэл

II.5. Худаг, усан сангийн тоо, усжуулалтын талаархи мэдээлэл

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТУУД

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр
- Хүснэгт 2. Газар тариалангийн үйлдвэрлэл
- Хүснэгт 3. Малтай өрх, малчин өрхийн тоо, сумаар
- Хүснэгт 4. Малтай өрх, малчин өрх, малчдын тоо
- Хүснэгт 5. Малчдын боловсролын түвшин, насны бүлгээр /2019 он/
- Хүснэгт 6. Малчдын гэрлэлтийн байдал, насны бүлгээр /2019 он/
- Хүснэгт 7. Эрүүл мэнд болон нийгмийн даатгалд хамрагдсан байдал, сумаар
- Хүснэгт 8. Зээлтэй малчид, сумаар
- Хүснэгт 9. Малчдын ахуй соёлын үзүүлэлт
- Хүснэгт 10. Малын тоо /мян, тол/
- Хүснэгт 11. Малын тоо, сумаар мянган толгойгоор
- Хүснэгт 12. Сүргийн насны ангилалын бүтэц, хувиар
- Хүснэгт 13. Сумдын мал сүргийн бүтэц, хонин толгойд шилжүүлсэн хувиар
- Хүснэгт 14. Малтай өрхийн ам бүлийн тоо, тэдгээрийн малын тоо, 2000-2019 он, мян тол
- Хүснэгт 15. Иргэдийн хувийн малын бүлэглэлт, 2018, 2019 он
- Хүснэгт 16. Хээлтэгч малын тоо
- Хүснэгт 17. Төл бойжилт, мянган толгойгоор
- Хүснэгт 18. 100 эхээс бойжуулсан төл, тоогоор
- Хүснэгт 19. Том малын зүй бусын хорогдол, тоогоор
- Хүснэгт 20. Оны эхний малд зүй бусын хорогдлын эзлэх хувь
- Хүснэгт 21. Хээл хаясан болон сувайрсан эх малын тоо
- Хүснэгт 22. Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь
- Хүснэгт 23. Хээлтүүлэгч малын тоо
- Хүснэгт 24. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо, малын төрлөөр
- Хүснэгт 25. Малын нийт хэрэглээний зарлага, мянган толгойгоор
- Хүснэгт 26. Оны эхний малд эзлэх хувь
- Хүснэгт 27. Хэрэглээний малын тоо, мянган толгойгоор
- Хүснэгт 28. Тэжээвэр амьтдын тоо
- Хүснэгт 29. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо, ам бүл
- Хүснэгт 30. Шинээр гаргасан худгийн тайлан
- Хүснэгт 31. Засварласан худгийн тайлан

Зургийн жагсаалт

- Зураг 1. ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь
- Зураг 2. Аймгийн нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь
- Зураг 3. Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь, сумаар /2019 он/
- Зураг 4. Малчдын насны бүтэц
- Зураг 5. Үндсэн болон туслах малчны харьцаа /2019 он/
- Зураг 6. Малчдын нийгэм, ахуйн нөхцлийг харуулах зарим үзүүлэлт
- Зураг 7. Нэг саяас дээш мал тоолуулсан он, малын тоо, мянган толгойгоор
- Зураг 8. Малын тоо, мянган толгойгоор
- Зураг 9. Аймгийн нийт малд сумдын малын эзлэх хувь
- Зураг 10. Малын тоо, сумаар.
- Зураг 11. Мал сүргийн бүтэц хувиар, таван төрлөөр
- Зураг 12. 200 хүртлэх малтай өрхийн тоо.
- Зураг 13. 1000-аас дээш малтай өрхийн тоо.
- Зураг 14. Бойжуулсан төл, мянган толгойгоор
- Зураг 15. Том малын зүй бусын хорогдол, тоогоор
- Зураг 16. Малын хээл хаялт, сувайралт

ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2019 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа. Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2019 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Засгийн газраас малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр багасгах талаар төрийн бодлого хэрэгжиж байгаатай холбоотойгоор хөдөө аж ахуй, нийгмийн салбарын төлөвлөлтөд нарийвчилсан тоо мэдээллийн хэрэгцээ бий болсон юм. Иймд ҮСХ-ны даргын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/185 тоот тушаалаар баталсан тооллогын маягтад малчдын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, эрчимжсэн мал ахуйтай холбоотой мэдээллийг шинээр нэмж тусгажээ. Өөрөөр хэлбэл мал аж ахуй эрхэлж буй малчин хүн бүрийн мэдээлэл статистикийн мэдээллийн санд орох болсноороо өмнөх жилүүдийн тооллогоос онцлог байлаа.

Энэхүү танилцуулгад мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн талаар тусгасан.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

МАЛ ТООЛЛОГЫН ТОВЧ ТҮҮХ

Мал аж ахуй нь Монгол орны хувьд амьжиргааны гол эх үүсвэр болсон анхдагч үйлдвэрлэлийн салбар байсны хувьд бүртгэл, статистикийн ажил ч энэ салбараас эхлэн хөгжсөн түүхтэй.

XIII зууны үед Монгол улсад хүн, малын тооллого явуулж байсан баримт түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Манжийн хараат байх үед Монголд мал тооллого явуулж байсан боловч нэгдсэн тооллого хийж чаддаггүй, орон нутгийн чанартай байв. Аймаг, хошуудад янз бүрийн хугацаанд, өөр өөрсдийн шаардлага үзэмжээр мал тооллого явуулж байсан байна.

Гадаад Монголын Засгийн газар 1918 онд хүн ам, малын тооллого явуулсан байна. Уг тооллого нь халхын 4 аймаг, лам, ноёд, шавь албат ардууд, сүм хийдийн малыг хамруулсан боловч Ховдын хязгаар, Дархадын хязгаар, Хөвсгөл нуур орчмын Богд гэгээний эзэмшил нутгийн мал ороогүй ажээ.

Ардын засгийн газар 1924 онд Дотоод яамны бүтцэд Тоо бүртгэлийн хэлтсийг шинээр байгуулж, мал тооллогыг үнэн зөв явуулах талаар онцгой анхаарч, тооллого явуулах, данс бүртгэлийг нэгтгэх, тушаах цаг хугацааг тогтоож, хуучин төлөөний түшмэл дээр боловсрол чадвартай тусгай түшмэлийг нэмэн томилж, ард олонд тайлбарлан таниулах ажлыг зохиосны үр дүнд анх удаа улсын хэмжээгээр хугацаа, аргачлалын хувьд нэгдсэн программтай мал тооллого явагдсан байдаг.

Мал тооллогод урьд өмнө нь бүртгэгдэхгүй байсан цаа буга, илжиг, луус, өвс хадлан, тариалангийн талаар зарим нэмэлт үзүүлэлтийг 1924 оноос эхлэн оруулсан байна. Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байсан бол 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болсон. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан, малчид өвөлжөөндөө бууж, хүн, малын хөдөлгөөн харьцангуй бага байдаг зэрэг давуу талтай юм.

Малын хашаа байрын тооллогыг 1966 оноос, худаг, малын тэжээлийн тооллогыг 1972 оноос нэмж мал тооллоготой хамтруулан явуулдаг болов. Ардын хувийн аж ахуйтны малыг 1959-1960 онд нийгэмчилж, хоршоололд хамруулж дууссан бол 1992 онд малыг хувьчлах ажил хийгдэж дууссан билээ.

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод 6 хонь - 1 бод

1 тэмээ - 1.5 бод 8 ямаа - 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ- 5 хонь 1 хонь - 1 хонь

1 адуу - 7 хонь 1 ямаа - 0.9 хонь

1 үхэр- 6 хонь

Нас гүйцсэн мал.Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай , 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал, Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч.Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцуулсан үзүүлэлтийг оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно. Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь.Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 - гаар үржүүлнэ.

Бойжилтийн хувь.Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл.Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур – 20-25 Бух – 35-45

Азарга- 12-15 Хуц, Ухна - 25-30

Малын зүй бус хорогдолд

өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бусын хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс - 0.45

Таримал тэжээл - 0.35

Даршны ургамал - 0.25

Гар тэжээл, хужир шүү - 1.0

Төмс ногооны хаягдал - 0.22

Үр тарианы хаягдал - 0.9

Лай - 0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

• Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.

2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.

3. Шүүст тэжээл- Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно. /
1тн=10 цн=1000кг /

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Эдийн засгийн бүсэд:

Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг


Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

НЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

I.1 Мал аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2018 оны байдлаар 116.2 тэрбум төгрөг болж, аймгийн ДНБ-ий 31.5 хувийг эзэлж өмнөх оноос 3.9 пунктээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 1. ДНБ-Д ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



I.2 Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт

Мал аж ахуйн салбарт 2019 онд нядалгааны жингээр 29.4 мянган тонн мах, 27.3 мянган литр сүү, 1037.3 тонн хонины ноос, 383.4 тонн ноолуур, 200.4 тонн тэмээний ноос, 439.6 мянган ширхэг арьс шир үйлдвэрлэв. малчдын зах зээлд борлуулсан, дотооддоо хэрэглэсэн махны хэрэглээ өмнөх оноос 3.7 хувиар, ноос, ноолуур 7.2 хувиар, арьс, шир 0.1 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 12.9 хувиар нэмэгдсэн байна. Мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо 2019 онд 760.3 мянга болж өмнөх оноос 15.2 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 1. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, биет хэмжээгээр

Бүтээгдэхүүн	хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
МАХ амьдын жингээр						
БҮГД	тонн	26689.3	22771.5	28367.8	29422.5	103.7
тэмээ	тонн	2331.9	2131.2	2670.7	3234.5	121.1
адуу	тонн	5229.8	3914.1	5178.4	5363.6	103.6

үхэр	тонн	4273.7	3151.0	3833.0	4049.0	105.6
хонь	тонн	8676.4	8278.4	10163.3	10792.2	106.2
ямаа	тонн	6176.3	5296.5	6521.3	5978.1	91.7
гахайн мах	тонн	1.2	0.3	1.1	5.1	4.6 ²
өндөг	мян.шир	166.9	80.8	274.5	303.0	110.4
СҮҮ		18917.5	22968.7	24156.4	27270.7	112.9
ингэний	тонн	1130.0	1241.5	1303.9	1300.5	99.7
гүүний	тонн	2207.4	3230.6	3081.1	3653.2	118.6
үнээний	тонн	8698.9	10492.1	11438.1	12877.3	112.6
хонины	тонн	2698.2	3043.6	3267.3	3654.8	111.9
ямааны	тонн	4182.9	4961.0	5066.0	5784.9	114.2
НООС НООЛУУР		1552.5	1542.1	1750.2	1875.5	107.2
тэмээний	тонн	168.9	176.6	190.7	200.4	105.1
бодын хялгас	тонн	22.2	20.0	22.7	24.3	107.0
хонины уртын ноос	тонн	841.6	849.4	964.9	1037.3	107.5
ямааны ноолуур	тонн	324.9	310.1	357.4	383.4	107.3
ямааны хялгас	тонн	194.9	186.0	214.5	230.1	107.3
АРЬС ШИР		399.7	357.0	439.1	439.6	100.1
тэмээ	мян.шир	5.1	4.6	5.8	7.0	120.7
адуу	мян.шир	20.0	15.0	19.8	20.5	103.5
үхэр	мян.шир	16.2	12.0	14.6	15.4	105.5
хонь	мян.шир	181.4	173.1	212.2	225.3	106.2
ямаа	мян.шир	175.7	150.9	185.4	170.1	91.7
хурга	мян.шир	0.5	0.5	0.5	0.5	102.0
ишиг	мян.шир	0.8	0.8	0.8	0.8	99.9

I.3. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт

Тайлант онд 7752.0 тн өвс хадлан, 219.4 тн гар тэжээл, 409.4 тн хужир шүү болон бусад тэжээл бэлтгэсэн мэдээг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 35.4 хувиар их, гар тэжээл 55.4 хувиар, хужир шүү 25.3 хувиар бага хураан авсан байна.

ХҮСНЭГТ 2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

	2016	2017	2018	2019	2019 2018
Өвс, хадлан, тн	6565	5448.9	5724.5	7752.0	135.4
Гар тэжээл, тн	129.5	537.4	492.1	219.4	44.6
Хужир, шүү, тн	204.8	943.5	548.1	409.4	74.7
Тариалсан талбай, га	80.5	98.4	78.5	63.8	81.3
Хураан авсан ургац, тн	466.9	446.7	328.4	309.2	94.2


ХОЁР. МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

II.1 Малтай өрх болон малчин өрх, малдчын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт

II.1.1 Малтай өрх, малчин өрхийн тоо

Аймгийн хэмжээний нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувийг авч үзвэл, 2000 онд 34.7 хувийг, 2005 онд 27.6 хувийг эзэлж байсан бол 2019 онд 21.1 хувийг эзэлж байна. 2000-2011 онд аймгийн нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь жил бүр буурч 19.0 хувьд хүрсэн бол 2012-2019 онуудад харьцангуй нэмэгдэж, дунджаар 19.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 2. АЙМГИЙН НИЙТ ӨРХӨД МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ




ХҮСНЭГТ 3. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, сумаар

Сумын нэр	2016		2017		2018		2019	
	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо
ДҮН	5 141	4 137	5 201	4 169	5 288	4 234	5351	4231
Айраг	418	334	426	317	433	331	440	350
Алтанширээ	326	290	330	279	335	294	337	290
Даланжаргалан	514	384	509	372	506	370	511	348
Дэлгэрэх	450	393	444	382	442	374	449	362
Иххэт	330	260	359	278	363	277	361	272
Мандах	349	301	356	315	365	321	377	340
Өргөн	312	244	294	240	321	256	333	255
Сайхандулаан	327	285	328	290	341	301	338	279
Улаанбадрах	355	304	359	303	358	300	358	310
Хатанбулаг	606	473	597	474	600	475	593	480
Хөвсгөл	324	274	336	286	348	301	345	291
Эрдэнэ	333	285	339	290	343	302	357	313
Сайншанд	393	246	427	276	430	267	445	277
Замын-Үүд	104	64	97	67	103	65	107	64

Малчин нэг өрхөд 518, малтай нэг өрхөд 440 толгой мал ногдож байгаа нь улсын дунджаас малчин өрхийнх 148, малтай өрхийнх 138 толгой малаар олон байна.

ЗУРАГ 3. НИЙТ ӨРХӨД МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сумаар /2019 он/




II.1.2 Малчдын мэдээлэл

2019 оны жилийн эцэст тус аймагт малтай 5351 өрх тоологдсны 4231 өрх буюу 79.1 хувь нь малчин өрх, 1120 өрх буюу 20.9 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна. Өмнөх онтой харьцуулахад малтай өрх 63-аар буюу 1.2 хувиар нэмэгдэж, малчин өрх 3-аар буюу 0.1 хувиар буурчээ. Малчин өрхийн ам бүлийн тоо нь 13.6 мянга болж нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 3 байна.

ХҮСНЭГТ 4. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО


	2016	2017	2018	2019	2019 2018
Малтай өрх	5141	5201	5288	5351	101.2
Малчин өрх	4137	4169	4234	4231	99.9
Малчдын тоо	7477	7232	7033	7024	99.9
үүнээс: 16-34 насны	2649	2516	2314	2149	92.9
35-59 насны	3955	3673	3675	3770	102.6
тэтгэврийн насны	873	1007	1020	1096	107.5
Нийт малчдаас эмэгтэй	3257	3043	2953	2958	100.2
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	390	443	468	518	110.7

ЗУРАГ 4. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ



Мал аж ахуйн салбарт ажиллаж буй малчдын тоо 2010 оноос жилд дунджаар 0.99% хувиар өссөн байна. 2019 онд малчдын тоо 7024 болсон нь өмнөх оноос 0.1 хувиар буюу 9 хүнээр буурсан байна. Нийт малчдын 2958 буюу 42.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 30.6 хувь нь 16-34 насны, 53.7 хувь нь 35-59 насны, 15.6 хувь тэтгэвэрийн насны хүмүүс байна. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлдэг малчдын 96.9 хувь нь 2019 онд үндсэн малчин, 3.1 хувь нь туслах малчид байна.

ЗУРАГ 5 ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧНЫ ХАРЬЦАА /2019 он/



Малчдын боловсролын түвшнийг 2018 оны байдлаар авч үзэхэд 23.9 хувь нь бага, 40.3 хувь нь суурь боловсролтой, 22.5 хувь нь бүрэн дунд, 6.2 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 3.2 хувь нь дээд боловсролтой байгаа бол 4.0 хувь нь боловсролгүй байна.

ХҮСНЭГТ 5. МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, насны бүлгээр /2019 он/

Насны бүлгээр	Бүгд	үүнээс:					Дээд
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	
ДҮН	7024	271	1590	3292	1047	610	214
15-34	2158	96	344	919	413	281	105
35-54	3499	146	729	1843	521	189	71
55 ба түүнээс дээш	1367	29	517	530	113	140	38
Дүнд эзлэх хувь							
ДҮН	100.0	3.9	22.6	46.9	14.9	8.7	3.0
15-34	100.0	4.4	15.9	42.6	19.1	13.0	4.9
35-54	100.0	4.2	20.8	52.7	14.9	5.4	2.0
55 ба түүнээс дээш	100.0	2.1	37.8	38.8	8.3	10.2	2.8

Нийт малчдын 5397 буюу 76.8 хувь нь 2019 оны байдлаар гэрлэсэн бөгөөд 64.4 хувь нь гэрлэлтээ батлуулсан, 12.4 хувь нь гэрлэлтээ батлуулаагүй байна. Харин 1001 малчин буюу 14.2 хувь нь огт гэрлээгүй, 427 малчин буюу 6.1 хувь нь бэлэвсэн, 96 буюу 1.4 хувь нь цуцалсан, 103 буюу 1.5 хувь нь гэрлэлтээ тусгаарласан байна.

15-34 насны малчдын 30.5 хувь нь огт гэрлээгүй бол 55 ба түүнээс дээш насны малчдын 21.1 хувь нь бэлэвсэн байна. Огт гэрлээгүй малчдын 65.7 хувь нь 34 хүртэлх насны малчид байна. Бэлэвсэн 427 малчны 82.4 хувь нь эмэгтэй малчид эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, насны бүлгээр /2019 он/

Насны бүлгээр	Бүгд	үүнээс:					
		Огт гэрлээгүй	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэсэн батлуул аагүй	Тусгаар ласан	Цуцалсан	Бэлэвсэн
ДҮН	7024	1001	4521	876	103	96	427
15-34	2158	658	1092	375	15	7	11
35-54	3499	274	2529	428	70	71	127
55 ба түүнээс дээш	1367	69	900	73	18	18	289
үүнээс: эмэгтэй							
ДҮН	2958	173	1996	365	40	32	352
15-34	819	80	567	156	3	3	10
35-54	1468	60	1077	175	30	21	105
55 ба түүнээс дээш	671	33	352	34	7	8	237

ХҮСНЭГТ 7. ЭРҮҮЛ МЭНД БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН байдал, сумаар

Сумын нэр	2018		2019	
	Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт	Нийгмийн даатгалд хамрагдалт	Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт	Нийгмийн даатгалд хамрагдалт
ДҮН	77.3	31.2	77.5	31.6
Айраг	73.4	37.1	76.7	45.5
Алтанширээ	75.5	28.8	80.0	27.6
Даланжаргалан	73.9	39.0	77.0	41.0
Дэлгэрэх	77.7	46.0	76.6	36.2
Иххэт	68.0	19.0	73.2	27.7
Мандах	79.1	28.9	81.3	26.2
Өргөн	65.9	27.9	71.6	26.1

Сайхандулаан	87.9	28.2	75.8	32.1
Улаанбадрах	67.3	39.7	63.7	21.8
Хатанбулаг	93.0	11.0	89.7	27.0
Хөвсгөл	68.8	23.8	63.3	24.5
Эрдэнэ	88.1	45.3	81.3	35.6
Сайншанд	73.1	35.1	88.3	30.2
Замын-Үүд	84.4	26.0	92.0	92.0

Нийт малчдын 45.2 хувь нь буюу 3176 малчин 2019 оны байдлаар зээлтэй байгаа ба 2018 онтой харьцуулахад 5.4 хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 8. ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, сумаар

Сумын нэр	Зээлтэй малчин		Зээлтэй малчдын нийт малчдад эзлэх хувь	
	2018	2019	2018	2019
ДҮН	3 012	3 176	42.8	45.2
Айраг	247	229	48.7	42.0
Алтанширээ	291	280	59.9	57.7
Даланжаргалан	257	270	47.9	54.5
Дэлгэрэх	398	339	56.1	51.8
Иххэт	214	260	49.0	58.6
Мандах	219	251	37.0	42.4
Өргөн	258	286	59.4	66.1
Сайхандулаан	199	195	40.9	44.0
Улаанбадрах	240	242	44.4	45.1
Хатанбулаг	105	150	13.1	18.3
Хөвсгөл	188	248	37.3	47.9
Эрдэнэ	226	180	44.0	34.6
Сайншанд	120	196	30.8	43.3
Замын-Үүд	50	50	52.1	57.5


II.1.3 Малчдын ахуйн зарим үзүүлэлт

2019 оны мал тооллогоор аймгийн нийт малчин өрхийн 84.5 хувь нь цахилгаан эх үүсвэртэй, 77.2 хувь нь телевизортой, 62.1 хувь нь автомашинтай, 70.9 хувь нь мотоциклтэй, 100.0 хувь гар утас хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ. Нийт өрхийн дүнд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад цахилгаан эх үүсвэртэй өрхийн тоо 6.1 пункт, телевизортой өрхийн тоо 6.6 пункт, мотоциклтой өрхийн тоо 9.3 пункт, автомашинтай өрхийн тоо 8.4 пунктээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 9. МАЛЧДЫН АХУЙ СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

	Өрхийн тоо			2019 2018	Малчин өрхийн дүнд эзлэх хувь			Өсөлт бууралт (пунктээр)
	2017	2018	2019		2017	2018	2019	
Нийт малчин өрх	4169	4234	4231	99.9				-
Цахилгаантай	3436	3320	3577	107.7	82.4	78.4	84.5	6.1
Телевизортой	2953	2991	3268	109.3	70.8	70.6	77.2	6.6
Автомашинтай	2114	2276	2629	115.5	50.7	53.8	62.1	8.4
Мотоциклтэй	2429	2605	2998	115.1	58.3	61.5	70.9	9.3
Гар утастай	4151	4234	4231	99.9	99.6	100.0	100.0	0.4

ЗУРАГ.6 МАЛЧДЫН НИЙГЭМ, АХУЙН НӨХЦЛИЙГ ХАРУУЛАХ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ



II.2. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн


II.2.1 Малын тоо

Нийт мал сүргийн тоо 2010-2019 онд жилд дунджаар 4.42 хувиар өссөөр, 2019 оны жилийн эцэст малын тоо 2404.2 мянган толгойд хүрсэн байна. Нийт малын тоо өмнөх оноос 11.9 хувь буюу 256.1 мянган толгойгоор өссөн. Мал сүргийн тоо таван төрөл дотор тэмээ 1.6 хувь, адуу 9.1 хувь, хонь 10.3 хувь, үхэр 14.0 хувь, ямаа 14.2 хувиар тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 10. МАЛЫН ТОО /мян.тол /

	2016	2017	2018	2019	2019	
					2018	
					Хувь	зөрүү
Бодоор	461.5	522.2	558.9	616.9	110.4	58.0
Толгойн тоо	1752.9	2001.6	2148.1	2404.2	111.9	256.1
Тэмээ	37.7	40.7	42.8	43.5	101.6	0.7
Адуу	118.7	133.2	139.9	152.6	109.1	12.7
Үхэр	63	72.6	80.6	91.9	114.0	11.3
Хонь	758.4	861.5	926.2	1021.6	110.3	95.4
Ямаа	775.2	893.6	958.6	1094.6	114.2	136.0

ЗУРАГ 7. НЭГ САЯАС ДЭЭШ МАЛ ТООЛУУЛСАН ОН, малын тоо, мянган толгойгоор




ЗУРАГ 8. МАЛЫН ТОО, мянган толгойгоор /1991-2019 он /




Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл ихээхэн нөлөөлж байсан байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсаны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2006, 2010, 2016 оны өвөл-хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан байна. Энэ хандлага тэмээнээс бусад 4 төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй хонь, ямаа хурдан өссөн байна. Харин тэмээн сүргийн хувьд 1990 оноос хойш буурч, 1995-2008 он хүртэл тогтвортой байсан бол 2009 оноос бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.

ЗУРАГ 9. АЙМГИЙН НИЙТ МАЛД СУМДЫН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ /2019 он/



ЗУРАГ 10. МАЛЫН ТОО, мянган толгойгоор, сумаар



ХҮСНЭГТ 11. МАЛЫН ТОО, сумаар, мянган толгойгоор

	2000	2010	2016	2017	2018	2019	2019 2018
ДҮН	1037.0	1057.0	1753.2	2001.6	2148.1	2404.2	111.9
Айраг	73.7	68.0	124.0	148.4	164.8	183.3	111.2
Алтанширээ	73.9	69.9	113.1	127.2	134.6	146.9	109.2
Даланжаргалан	99.0	82.4	154.4	174.7	176.4	196.8	111.5
Дэлгэрэх	94.7	127.1	170.1	186.2	206.2	233.1	113.1
Иххэт	67.2	72.5	139.7	167.2	164.1	177.1	107.9
Мандах	70.0	65.0	132.2	154.0	171.4	189.0	110.3
Өргөн	85.3	67.4	113.9	128.3	152.8	169.9	111.2
Сайхандулаан	63.4	63.4	145.0	164.8	182.2	193.1	106.0
Улаанбадрах	85.0	87.0	121.6	138.6	140.5	157.3	112.0
Хатанбулаг	102.0	149.0	201.3	228.4	228.6	260.2	113.8
Хөвсгөл	68.0	72.3	104.9	121.7	143.0	159.1	111.3
Эрдэнэ	80.3	60.6	113.0	125.6	135.4	151.9	112.2
Сайншанд	64.1	52.4	94.9	109.6	117.8	132.1	112.2
Замын-үүд	10.4	20.0	25.1	26.9	30.3	54.3	179.3


II.2.2 Нийт сүргийн бүтэц

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг 2019 оны байдлаар авч үзвэл, ямаа 45.5 хувь, хонь 42.5 хувь, үхэр 3.8 хувь, адуу 6.3 хувь, тэмээ 1.8 хувийг эзэлж байна. 1975 оноос хойш 43 жилийн хугацаанд тэмээний тоо толгой 57.1 хувиар буурсан байхад ямааны тоо толгой 7.5 дахин нэмэгджээ. Сүүлийн 43 жилийн хугацаанд мал сүргийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзэхэд, ямааны эзлэх хувь 29.6 пунктээр өсөж, харин хониных 13.0 пункт, үхрийнх 8.8 пункт, тэмээнийх 6.5 пункт, адууных 1.4 пунктээр буурчээ.

Малын тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдсэнээс гадна таван төрлийн малын харьцаа, сүргийн бүтэцэд томоохон өөрчлөлт гарсан байна. 1975-1990 оны улсын мал тооллогын 15 жилийн үр дүнгээс үзэхэд сүрэгт бод мал дунджаар 26.4 хувь, бог мал дунджаар 73.6 хувийг эзэлдэг байсан бол 2019 оны байдлаар бод мал дунджаар 12.0 хувь, бог мал дунджаар 88.0 хувийг эзлэх болж, бод малын хувийн жин 14.4 пунктээр буурч, бог малынх 14.4 пунктээр нэмэгджээ.

Манай улсын хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд нэг ямаа ногдож байсан. Бог малд хонь 75.0 орчим хувь, ямааны тоо 25.0 орчим хувь байхад сүргийн бүтэцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой байсан уламжлалт харьцаа алдагдсаар 25 орчим жил болж байна.

ЗУРАГ 11. МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ, таван төрлөөр /2016-2019 он/



ХҮСНЭГТ 12. СҮРГИЙН НАСНЫ АНГИЛАЛЫН БҮТЭЦ, хувиар

	Төл, өсвөр насны мал				2019- 2018	Нас гүйцсэн эр				2019- 2018
	2016	2017	2018	2019		2016	2017	2018	2019	
Бүгд	30.0	33.1	30.5	32.4	1.9	25.4	23.7	25.3	24.7	-0.6
Тэмээ	44.5	44.5	45.1	45.8	0.7	14.8	14.7	14.1	13.4	-0.7
Адуу	38.9	40.5	41.3	43.3	2.0	24.1	22.3	21.5	19.4	-2.1
Үхэр	46.8	47.4	49.1	48.5	-0.6	10.6	10.3	10.0	10.2	0.2
Хонь	31.9	33.8	31.6	33.3	1.7	22.3	21.4	22.5	21.8	-0.7
Ямаа	24.6	29.7	25.6	28.1	2.5	30.4	27.6	30.4	29.8	-0.6

	Хээлтэгч				2019- 2018	Хээлтүүлэгч				2019- 2018
	2016	2017	2018	2019		2016	2017	2018	2019	
Бүгд	43.7	42.3	43.3	42.0	-1.3	0.9	0.9	0.9	0.9	0.0
Тэмээ	39.5	39.6	39.6	39.5	-0.1	1.2	1.2	1.2	1.3	0.1
Адуу	32.1	32.5	32.5	32.7	0.2	4.9	4.7	4.7	4.6	-0.1
Үхэр	41.3	40.8	39.5	39.9	0.4	1.3	1.5	1.4	1.4	0.0
Хонь	45.1	44.1	45.2	44.2	-1.0	0.7	0.7	0.7	0.7	0.0
Ямаа	44.5	42.2	43.5	41.6	-1.9	0.5	0.5	0.5	0.5	0.0

ХҮСНЭГТ 13. СУМДЫН МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ, хонин толгойд шилжүүлсэн мянган толгойгоор

Сум	Бүх хонин толгой, мянга	Үүнээс төрлөөр				
		тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
ДҮН	3843.9	217.6	1068.3	551.3	1021.6	985.1
Айраг	263.1	5.3	70.8	26.9	92.9	67.3
Алтанширээ	224.6	2.6	63.0	32.3	78.8	47.9
Даланжаргалан	281.9	3.9	68.3	37.9	100.0	72.0
Дэлгэрэх	385.7	6.4	123.1	60.2	122.3	73.8
Иххэт	278.4	0.9	80.2	46.8	87.6	63.1
Мандах	287.7	39.9	67.3	23.6	61.9	95.0
Өргөн	270.9	7.1	71.2	49.9	76.9	65.8
Сайхандулаан	310.1	22.8	82.7	44.0	81.5	79.1
Улаанбадрах	280.9	26.9	84.8	44.2	57.3	67.7
Хатанбулаг	417.5	39.6	100.5	65.1	79.2	133.1
Хөвсгөл	256.5	26.3	71.1	29.3	48.8	81.1
Эрдэнэ	282.6	14.6	101.2	47.3	55.2	64.3
Сайншанд	220.4	16.4	64.8	31.1	51.4	56.7
Замын-үүд	83.3	4.7	19.4	12.8	28.0	18.5

II.2.3 Иргэдийн хувийн малын тоо

2019 онд аймгийн хэмжээгээр аминдаа малтай 5351 өрхийн малын тоо энэ онд 2353.1 мянган хүрсэн нь нийт малын 97.9 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 11.2 хувь буюу 237.7 мянган толгой малаар өссөн байна.

ХҮСНЭГТ 14. МАЛТАЙ ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО, ТЭДГЭЭРИЙН МАЛЫН ТОО, 2000-2019 он, мянган толгойгоор


Он	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Бүгд	Үүнээс :				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2000	6283	24659	960.5	26.7	113.8	83.5	408.3	328.2
2005	5020	19018	933.5	26.3	77.5	43.3	352.0	434.4
2010	4460	15593	1031.4	26.9	76.1	39.4	408.9	480.1
2011	4554	15886	1180.7	28.7	85.0	44.5	464.1	558.3
2012	4593	16071	1301.7	30.2	94.1	49.1	518.8	609.5
2013	4716	16361	1486.4	31.6	105.5	58.0	598.1	693.2
2014	4824	16401	1655.1	33.6	119.2	63.9	676.4	762.1
2015	5020	16371	1767.7	34.8	129.8	68.2	736.5	798.5
2016	5141	13470	1752.9	37.7	118.7	63.0	758.4	775.2
2017	5201	16929	1971.1	39.6	131.5	70.9	846.9	882.2
2018	5287	16951	2115.4	41.7	138.2	78.8	910.5	946.2
2019	5351	16889	2353.1	42.4	150.8	90.2	990.5	1079.2

ХҮСНЭГТ 15. ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, 2018, 2019 он


	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо, мян.тол	
	2018	2019	2018	2019	2018	2019
Бүгд	5288	5351	100.0	100.0	2116.4	2353.1
10 хүртэл малтай	93	78	1.8	1.5	0.6	0.5
11-30 хүртэл малтай	258	235	5.0	4.4	5.7	5.0
31-50 хүртэл малтай	258	250	5.0	4.7	10.6	10.2
